

9. Ядуурлын үндсэн үзүүлэлтүүдийг зөв харгалзуулна уу?

/2 оноо/

1	Ядуурлын хамрах хүрээ	a	Ядуурлын шугамаас ядуусын хэрэглээ хэр зэрэг доогуур болохыг үзүүлдэг.
2	Гүнзгийрлийн индекс	b	Ядуу болон ядуу бус хүн амын хэрэглээний зөрөөг илтгэнэ.
3	Тэгш бус байдлын Жини коэффициент	c	Нийт хүн амын хэдэн хувь нь ядууралд өртсөн болохыг харуулна.

A. 1c 2a 3b B. 1b 2c 3a C. 1a 2b 3c D. 1c 2b 3a E. 1a 2c 3b

10. Цэгийн оронд тохирох хариултыг олно уу?гэдэг нь иргэдийн тэр дундаа доод давхаргын нийгмийн нөхцөл байдлыг сайжруулах, амьжиргааны түвшин эрс буурах эрсдэлд өртүүлэхгүйн тулд төрөөс хэрэгжүүлдэг цогц арга хэмжээг хэлнэ. **/1 оноо/**

A. Нөхцөлт мөнгөн тусламж B. Нийгмийн даатгалын сан C. Нийгмийн халамж
D. Тэтгэврийн нөхөн олговор E. Нийгмийн хамгааллын тогтолцоо

11. Нийгэмд тогтсон хэм хэмжээ алдагдсаны улмаас соёлын нэгдэл зөрчигдөхийг соёлын гажилт гэж үзсэн эрдэмтэн хэн бэ? **/1 оноо/**

A. Э. Кассирер B. Э. Тайлор C. Ж. Мёрдок D. Э.Дюркгейм E. К.Ясперс

12. Цэгийн оронд тохирох хариултыг олно уу?нь хүмүүс хоорондоо болон нийгэмтэйгээ харилцах хэм хэмжээ, ойлголтуудын цогц юм. **/1 оноо/**

A. Ёс суртахуун B. Ёс суртахууны хэм хэмжээ C. Ёс суртахууны ухамсар
D. Ёс суртахууны харилцаа E. Ёс суртахууны үйлдэл

13. Харилцан үйлчлэлтэй буюу хоёр талтай, эсвэл нэг талтай, зарим тохиолдолд өөрчлөлтийг засгийн газраас хүчээр тулгах явдал нь соёлын өөрчлөлтийн ямар эх үүсвэрт хамаарах вэ? **/1 оноо/**

A. Сэтгэлгээний өөрчлөлт B. Байгаль орчны өөрчлөлт C. Шинэ нээлт, бүтээл
D. Өөр хэм хэмжээ үнэт зүйлс, технологи бүхий бүлгүүдтэй холбоо тогтоох явдал
E. Хүн ам зүйн өөрчлөлт

14. Нийгмийн харилцааны явцад тухайн үндэстэнд түүхэн ёсоор бүрэлдэн бий болсон хэлийг юу гэж нэрлэх вэ? **/1 оноо/**

A. Зохиомол хэл B. Төрөлх хэл C. Шинжлэх ухааны хэл
D. Ердийн хэл E. Философийн хэл

15. Дараах ойлголтуудын аль нь албан бус хэм хэмжээнд хамаарахгүй вэ? **/2 оноо/**

A. Иргэн бүр орлогоо зөв мэдүүлж татвараа төлөх
B. Манлайлагчийн чанаруудыг хүлээн зөвшөөрөх
C. Хүн бүр өөрийн овог, удам, гарал угсаагаа мэддэг байх
D. Монголчуудын зочлох, хүндлэх ёсыг хүндэтгэх
E. Иргэн бүр төрийн дууллаа мэддэг байх

16. Өөрийгөө, орчноо сайхнаар авч явах, бүтээх, эв зохицолт, төлөв төрхтэй байдлыг эрхэмлэх зэрэгт соёл нь ямар хэлбэрээр илрэн гарч байна вэ? **/1 оноо/**

A. Ахуйн соёл B. Эдийн засгийн соёл C. Гоо сайхны соёл
D. Экологийн соёл E. Сэтгэлгээний соёл

17. Сүсэг бишрэлийн нийтлэг байдлаас улбаалан хүмүүсийн бэлгэдэл, үнэт зүйлс, эрмэлзэл нэг байхыг юу гэж нэрлэдэг вэ? **/1 оноо/**

A. Үндэсний соёл B. Зонхилогч соёл C. Нийтийн соёл
D. Шашны соёл E. Мэргэжлийн соёл



18. Хүн бүр суралцах, амьдарч ажиллах, аялж зугаалах гэх мэт янз бүрийн зорилгоор гадаад орныг зорьдог. Хэдийгээр сайхан бүхнийг төсөөлөн очдог ч харь оронд мэдэхгүй хэлээр дасал болоогүй хүмүүстэй харилцаж, дасан зохицож амьдрах явцад гардаг бэрхшээлийг юу гэж нэрлэх вэ? **/2 оноо/**

- A. Соёлын нэгдэл В. Соёлын гажилт С. Соёлын хожимдолт
D. Харийн соёлын ноёрхол Е. Соёлын цочирдол

19. Дараах бодомжуудын аль нь буруу томъёологдсон байна вэ? **/2 оноо/**

- A. Нийгмийн анги, угсаа гарал, шашин, оршин суух нутаг зэрэг хүчин зүйлийн нөлөөгөөр дэд соёл бүрддэг.
B. Оюуны соёлын өвөрмөц үзэгдэл бол урлаг юм.
C. Ардын соёл нь тухайн улс үндэстний гэж хэлж болох өвөрмөц шинжийг өөртөө шингээсэн байдаг.
D. Уран зураг, уран барилга, симфони найрал хөгжим зэрэг нь сонгодог соёлын төрөл юм.
E. Нийтийн соёл нь соёлын бусад хэлбэрийг бодвол уран сайхны үнэ цэн нь өндөр байдаг.

20. Дараах өгөгдлүүдийг зөв харгалзуулна уу? **/1 оноо/**

1	Үндэсний соёл	a	Үр хүүхдээ асрах, ахмад настнаа хүндэтгэх
2	Байгууллагын соёл	b	Хуримын зан үйл , тэмдэглэлт өдрүүд
3	Хувь хүний соёл	c	Алсын хараа эрхэм зорилгоо тодорхойлж уриа дэвшүүлэх

- A. 1a 2c 3b В.1a 2b 3c С.1c 2a 3b D. 1b 2c 3a E.1c 2b 3a

21. НЭ<НН үед макро эдийн засагт ямар үзэгдэл бий болох вэ? **/1 оноо/**

- A. Үйлдвэрлэсэн баялгийн борлуулалт буурснаар эдийн засаг уналтад орж ажилгүйдэл үүснэ.
B. Бүтээгдэхүүн үйлчилгээний үнэ өсч инфляци бий болно.
C. Макро эдийн засагт тэнцвэр бий болно.
D. Макро эдийн засагт ямар нэг сөрөг үзэгдэл бий болохгүй.
E. Тохирох хариулт алга.

22. ДНБ -г орлогоор нь тодорхойлохдоо илүүц зүйл оруулсан бол аль нь вэ? **/1 оноо/**

- A. Түрээсийн төлбөр В. Зээлийн хүү С. Өрх гэрийн хэрэглээний зардал
D. Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын шимтгэл Е. Шууд бус татвар

23. Вексель гэж юу вэ? **/1 оноо/**

- A. Банкны хадгаламжид үндэслэн нэг тооцооны данснаас нөгөөд мөнгө шилжүүлэх банк хоорондын тооцооны тогтолцоо
B. Тодорхой хугацаанд өрөө төлөх тухай зээлдэгчийн хүлээсэн үүргийг гэрчилсэн өр төлөх баталгаа
C. Төв банкнаас гаргадаг мөнгөн тэмдэгт, банкны тасалбар
D. Данснаас тодорхой хэмжээний мөнгө авах тухай өмчлөгчийн зөвшөөрөл
E. Компьютерийн тусламжтайгаар хийгддэг банкны тооцооны тогтолцоо

24. Төв банкны үүрэгт аль нь хамаарах вэ? **/2 оноо/**

- A. Мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах В. Мөнгөн хадгаламжийг хүлээж авах
C. Иргэдэд мөнгөн зээл олгох D. Мөнгөн гүйлгээ хийх
E. Зээлийн бүтээгдэхүүн гаргах



25. Дараах бодомжуудын аль нь ажил эрхлэлтийн түвшинг зөв тодорхойлсон байна вэ? **/1 оноо/**
- A. Хөдөлмөрийн чадвартай хүн амын тоог хөдөлмөрийн насны хүн амд харьцуулах
 - B. Хөдөлмөрийн чадвартай ажилгүй хүн амын тоог эдийн засгийн идэвхтэй хүн амын тоонд харьцуулах
 - C. Хөдөлмөрийн чадвартай хүн амын тоог эдийн засгийн идэвхтэй хүн амын тоонд харьцуулах
 - D. Хөдөлмөрийн чадвартай ажилгүй хүн амын тоог хөдөлмөрийн насны хүн амын тоонд харьцуулах
 - E. Ажиллагчдын тоог хөдөлмөрийн насны хүн амын тоонд харьцуулах

26. Эдийн засагт үнийн ерөнхий түвшин байнга өсч мөнгө үнэгүйдэх үзэгдлийг юу гэж нэрлэх вэ? **/1 оноо/**
- A. Хэрэглээний үнийн индекс
 - B. Дефляци
 - C. Хэрэглээний сагс
 - D. Инфляци
 - E. Хэрэглээний бараа үйлчилгээний жин

27. Демпинг гэж юуг хэлдэг вэ? **/1 оноо/**
- A. Дотоодын зах зээл дээр орж ирж буй импортын барааны тоо хэмжээ, үнэд хязгаарлалт тогтоох
 - B. Бусад улс орнуудтай тогтоосон худалдааны харилцааг зохицуулах зорилгоор төрөөс авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний нийлбэр
 - C. Үйлдвэрлэгчид гадаад орнуудын шинэ зах зээлд нэвтрэхийн тулд өрсөлдөгчөөсөө доогуур үнээр бараагаа шахаж дараа нь үнэ өсгөх зорилготой түр зуурын үзэгдэл
 - D. Дотоодын ААН-үүдийн гаднаас оруулж ирж буй бараанд ноогдуулах импортын татвар
 - E. Бүтээгдэхүүн экспортлохын оронд гадаадад үйлдвэрээ байгуулах эсвэл худалдаж авах

28. Дараах өгөгдлүүдийг зөв харгалзуулна уу? **/2 оноо/**

1	$M = \frac{PQ}{T}$	a	Энэ үед эдийн засагт мөнгөний хомсдол үүсэж нийт эрэлт буурахад хүрнэ.
2	$M > \frac{PQ}{T}$	b	Энэ үед гүйлгээнд байгаа мөнгөний тоо хэмжээ, үйлдвэрлэсэн бараа, үйлчилгээний үнийн дүнтэй тэнцэж эдийн засаг тогтвортой хөгжинө.
3	$M < \frac{PQ}{T}$	c	Энэ үед эдийн засагт мөнгөний илүүдэл бий болж мөнгө үнэ цэнээ алдаж инфляци үүснэ.

- A. 1a 2c 3b B. 1b 2c 3a C. 1c 2a 3b D. 1b 2a 3c E. 1a 2b 3c

29. Нөхөж бичнэ үү? Гадаад худалдааны тэнцэл гэдэг нь хэлнэ. **/2 оноо/**
- A. Экспорт, импортын зөрүүг хэлнэ.
 - B. Экспорт, импортын нийлбэрийг хэлнэ.
 - C. Улс орнуудын хооронд бараа, үйлчилгээний шилжих хөдөлгөөнийг хэлнэ.
 - D. Бүтээгдэхүүн үйлчилгээг гадаад орнуудад борлуулахыг хэлнэ.
 - E. Бүтээгдэхүүн үйлчилгээг гадаад орнуудаас худалдаж авахыг хэлнэ.

30. Монгол оронд усан үзэм тариалахад гарах зардал БНХАУ-д тариалснаас өндөр гарах нь ойлгомжтой. Учир нь Монголд усан үзмийг зөвхөн хүлэмжинд ургуулах боломжтой. Харин Хятадын зөөлөн дулаан уур амьсгалтай өмнөд нутгийн задгай хөрсөнд бараг зөнгөөрөө ургана. Үүнийг гадаад худалдааны ямар онолоор тайлбарлаж болох вэ? **/2 оноо/**
- A. Хөрөнгө оруулалтын онол
 - B. Протекционист онол
 - C. Харьцангуй /туйлын/ давуу талын онол
 - D. Тарифийн хязгаарлалт
 - E. Квотын хязгаарлалт



31. Улс төрийн нам, мэргэжлийн холбоо гэх мэт нь улс төрийн хэрэгжилтийн ямар түвшинд хамаарах вэ? **/1 оноо/**
 А. Теологийн түвшин В. Макро түвшин С. Мега түвшин
 D. Микро түвшин E. Рациональ түвшин
32. Эрх мэдлийг бихевиорист хандлагын үүднээс хэрхэн тодорхойлох вэ? **/1 оноо/**
 А. Эрх мэдэл нь захирагч захирагдагч хоёрын харилцааны нэг өвөрмөц шинж
 В. Эрх мэдэл гэдэг нь тавьсан зорилгоо хэрэгжүүлэх чадвар, үйл ажиллагаа
 С. Эрх мэдэл гэдэг нь нийгмийн бүлгийн өөрсдийгөө зохион байгуулах арга хэрэгсэл
 D. Эрх мэдэл гэдэг нь улс төрийг хэрэгжүүлэх хэрэгсэл
 E. Эрх мэдэл гэдэг нь улс төрийн зан үйлийн өвөрмөц хэв маяг
33. Дараах бодомжуудын аль нь улс төрийн тогтолцооны гадаад шаардлагад хамаарах вэ? **/1 оноо/**
 А. Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэхийг шаардах В. Сонгуулийн хуулийг өөрчлөх
 С. Засгийн газрыг огцруулах D. Төсвийн тодотгол хэлэлцэх
 E. УИХ-ын байнгын хорооны даргыг өөрчлөх
34. АНУ-ын улс төр судлаач А.Алмонд өөрийн гэсэн зорилго чиглэлтэй зохион байгуулалттай бүлгийг сонирхлын бүлгийн ямар хэв шинжид хамаарна гэж үзсэн вэ? **/1 оноо/**
 А. Эвсэл холбооны бус бүлэг В. Аномик бүлэг С. Эвсэл холбооны бүлэг
 D. Байгууллагажсан бүлэг E. Үзэл сурталжсан бүлэг
35. Олон намын тогтолцооны ач холбогдлыг тоочихдоо илүүц зүйл дурьдсан бол аль нь вэ? **/2 оноо/**
 А. Бусад нам хөдөлгөөнийг хориглодог В. Нэг нам ноёрхох боломжийг хязгаарладаг
 С. Засаглалын тэнцвэрийг хадгалах нөхцөл бүрддэг
 D. Олон ургальч үзлийг дэмждэг E. Хүний эрхийг хангадаг
36. Иргэдийн улс төрийн оролцооны хэлбэрийг олон нийт хэр зэрэг хүлээн зөвшөөрдөг эсэхээс нь хамаарч юу гэж ангилдаг вэ? **/1 оноо/**
 А. Нийцтэй ба нийцгүй В. Хуулийн хүрээнд ба хууль бус
 С. Идэвхтэй ба идэвхгүй D. Сайн дурын ба албадлагын
 E. Уламжлалт ба уламжлалт бус
37. Төрийн засаглалын хэлбэрүүдийг зөв харгалзуулна уу? **/2 оноо/**
- | | | | |
|---|-------------------------|---|-----------------------|
| 1 | Парламентын засаглал | a | Унгар, ХБНГУ, Энэтхэг |
| 2 | Ерөнхийлөгчийн засаглал | b | Грек, Франц, Молдав |
| 3 | Холимог засаглал | c | АНУ, ОХУ, БНСУ |
- А. 1c 2b 3a В. 1b 2c 3a С. 1b 2a 3c D. 1a 2c 3 b E. 1c 2a 3b
38. “Ардчилалд олон сул тал бий. Гэхдээ түүнд нэг давуу тал бий. Одоо хүртэл хэн ч ардчиллаас өөр давуу сайн зүйлийг бий болгоогүй” гэж хэн хэлсэн бэ? **/2 оноо/**
 А. Ж.Локк В. А.Линкольн С. К. Поппер
 D. Т.Жефферсон E. У. Черчилль
39. “Иргэд төрийн хэрэгт шууд оролцож, сонгож байгуулсан төрийн эрх барих байгууллагаараа уламжлан эрхээ эдэлнэ” гэсэн нь ардчиллын аль хэлбэрийг илэрхийлж байна вэ? **/2 оноо/**
 А. Сонгодог ардчилал В. Шууд ардчилал С. Төлөөллийн ардчилал
 D. Оролцооны ардчилал E. Элитийн ардчилал



40. Өрсөлдөгчөөсөө олон санал авсан улс төрийн нам дангаараа Засгийн газар байгуулах боломжийг түлхүү олж авдаг. Энэ нь сонгуулийн тогтолцооны ямар хэлбэр вэ? **/1 оноо/**
 А. Дийлэнх олонхийн тогтолцоо В. Хувь тэнцүүлэх тогтолцоо
 С. Холимог тогтолцоо D. Ердийн тогтолцоо E. Зонхилох тогтолцоо
41. Монгол улсын төрийн эрх мэдлийн хуваарилалтыг ямар хуулиар баталгаажуулсан байдаг вэ? **/1 оноо/**
 А. Үндсэн хууль В. Төрийн албаны тухай хууль
 С. Захиргааны ерөнхий хууль D. Захиргааны хариуцлагын тухай
 E. Улс төрийн намын тухай хууль
42. Иргэний эрх зүйн харилцааны төрөлд аль нь хамааралгүй вэ? **/2 оноо/**
 А. Газрын эрх В. Нэр төр, алдар хүндтэй холбоотой харилцаа
 С. Эд хөрөнгийн өмчлөл D. Гэр бүлийн харилцаа E. Эрүүгийн зөрчил, маргаан
43. Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн зохицуулалтаар хэнийг тусгайлсан хамгаалалтад авдаг вэ? **/1 оноо/**
 А. Олзлогдсон иргэд В. Энгийн иргэд С. Шархтан ба өвчтнүүд
 D. Хүүхдүүд E. Цэрэг, офицерууд
44. Нөхөж бичнэ үү.гэдэг нь төрийн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, шинэчлэх талаар гаргасан хүсэлтийг хэлнэ. **/1 оноо/**
 А. Гомдол В. Санал С. Мэдэгдэл D. Гэрээ E. Хэлцэл
45. Жижиг бизнес эрхэлж буй иргэдийн албан татварыг орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ эрхлэгч иргэний орлогын албан татварын тухай хуулиар зохицуулдаг. Жишгээр татвар төлдөг ажил үйлчилгээ эрхлэгч аль нь вэ? **/2 оноо/**
 А. Цэцэг ургамал тарьж худалдах В. Лангуугаар худалдаа эрхлэгч
 С. Түлээ нүүрс борлуулагч D. Чингэлэг, тээврийн хэрэгсэл дээрээс худалдаа эрхлэгч
 E. Тохирох хариулт алга
46. Үндсэн хуулийн цэц төрийн албан хаагчийн өргөдлөөр маргаан үүсгэн хянан шийдвэрлэж болох уу? **/1 оноо/**
 А. Шийдвэрлэж болохгүй В. Шийдвэрлэж болно С. Зарим тохиолдолд болно
 D. Маргаан үүсгэсэн асуудлын шинж байдлаас хамаарна.
 E. Хэрвээ захиргааны албан хаагч өргөдөл гаргасан бол болно.
47. НҮБ-д Хүүхдийн эрхийн тухай конвенцийн нэмэлт протоколд 15 нас хүрээгүй хүүхдийг ямар үйл ажиллагаанд татан оролцуулбал дайны гэмт хэрэгт тооцдог вэ? **/2 оноо/**
 А. Зэвсэгт хүчин эсвэл зэвсэгт бүлэглэлд оролцуулах В. Албадан цэрэгт татах
 С. Дайн байлдаанд шууд оролцуулах
 D. Эрүүл мэндийн тусламж үзүүлэхээс татгалзах E. Албадан байцаах
48. Цагдаагийн байгууллага ямар чиг үүргийг хэрэгжүүлдэг байгууллага вэ? **/1 оноо/**
 А. Өмгөөлөх В. Хяналт тавих С. Гэм бурууг тогтоох
 D. Шалгах E. Биелүүлэх
49. Хууль тогтоох, хэрэгжүүлэх, шийдвэр гаргах зэрэгт иргэдийн зүгээс шууд болон шууд бусаар оролцох, үзэл бодлоо илэрхийлэх, хамтран шийдвэр гаргах эрхтэй байх нь төртэй харилцагч иргэнд тавигдах нийтлэг шаардлагын аль нь вэ? **/1 оноо/**
 А. Хяналт тавигч иргэн байх В. Мэдээлэлтэй иргэн байх
 С. Оролцогч иргэн байх D. Сонгогч иргэн байх
 E. Санхүүжүүлэгч иргэн байх



50. Хууль сахиулах байгууллагын албан тушаалтнууд хүний эрхийг хязгаарлах эрх хэмжээтэй байдаг тул тэдний хувьд тодорхой үйлдлүүдийг хориглодог. Тэрхүү хориглодог үйлдлүүдийг тоочихдоо илүүц зүйл дурьдсан бол аль нь вэ? **/2 оноо/**

- A. Гэм буруугүй хүнийг сэжигтэн, яллагдагчаар тооцох
 B. Хохирлыг тодорхойлох, хохирогчийг хамгаалах
 C. Хүнийг хууль бусаар баривчлах
 D. Эрүү шүүлт тулгах
 E. Нотлох баримтыг хуурамчаар бүрдүүлэх

51. Олон улсын эрх зүйд ямар ч тохиолдолд гажиж үл болох хэм хэмжээг юу гэж нэрлэдэг вэ? **/1 оноо/**

- A. Императив
 B. Экстенсив
 C. Прогрессив
 D. Интенсив
 E. Диспозитив

52. Олон улсын харилцааны түүх судлаачид 1618-1648 оны хооронд Европ тивд болсон 30 жилийн дайны төгсгөлд байгуулсан энхийн гэрээгээр орчин үеийн олон улсын харилцааны түүх эхэлсэн гэж үздэг. Энэ нь ямар гэрээ вэ? **/1 оноо/**

- A. Ялтын гэрээ
 B. Женевийн гэрээ
 C. Хиагтын гэрээ
 D. Буурын гэрээ
 E. Вестфалийн гэрээ

53. Дараах өгөгдлүүдийн аль нь олон улсын харилцааны олон туйлт системийн гол онцлог шинжийг илэрхийлж байна вэ? **/1 оноо/**

- A. Нөгөө хоёр талтай аль алинтай нь сайн харилцаатай байх, зөрчил үүсэхээс болгоомжилдог.
 B. Өөрийн нөлөөнд буй улс орнуудын хоорондын зөрчилдөөнийг зохицуулах, эвсэлд нэгдсэн орнуудын салан тусгаарлах болон бие даах оролдлогыг таслан зогсоодог.
 C. Нөгөө эвсэлтэй тэмцэлдэх, боломжтой бол устгахыг оролддог
 D. Аль нэг талтай нь дайтсан ч системийг бүхэлд нь тогтворгүйжүүлэх хэрэггүй.
 E. Өөрсдийн хүчийг нэмэгдүүлэхийг байнга эрмэлздэг, нөгөө эвслийн гишүүнийг өөртөө татах, өөрийн гишүүдийг алдахгүйн төлөө тэмцдэг.

54. Монгол улс дараах байгууллагуудад гишүүнээр элсэн орсон он цагийг зөв харгалзуулна уу. **/2 оноо/**

1	1961 онд	a	Ази – Европын уулзалт /АСЕМ/
2	2004 онд	b	Нэгдсэн Үндэстний Байгууллага
3	2006 онд	c	Азийн хамтын ажиллагааны яриа хэлэлцээ /АСД/

- A. 1b 2a 3c B. 1a 2c 3b C. 1b 2c 3a D. 1c 2b 3a E. 1c 2a 3b

55. Олон улсын эрх зүйн хэм хэмжээний төрлүүдийг тоочихдоо илүүц зүйл дурьдсан бол аль нь вэ? **/1 оноо/**

- A. Урьдчилан бичигдсэн агуулгын шинжээрээ ангилагдах хэм хэмжээ
 B. Хамтын ажиллагааны хэм хэмжээ
 C. Эрх зүйн үйлчлэх хүчний хэм хэмжээ
 D. Тодорхойлолтын хэм хэмжээ
 E. Зарчмын хэм хэмжээ

56. Монгол улсаас дэлхий нийтийн хэмжээнд явуулж байгаа гадаад бодлогын хүрээнүүдийг тоочихдоо илүүц зүйл дурьдсан бол аль нь вэ? **/1 оноо/**

- A. Европын улсууд
 B. Ази, Номхон далайн улсууд
 C. Арлын болон эх газрын улсууд
 D. Тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн орнууд
 E. Ойрхи Дорнод, Африк, Латин Америкийн улсууд



ХОЁРДУГААР ХЭСЭГ**Санамж:**

1. Энэ хэсэг сонгох даалгавар биш тул харгалзааг зөв тогтоож, хариуг бөглөөрэй.
2. Зөв харгалзуулсан хариулт бүр 1 оноо

2.1 Дараах өгөгдлийг зөв харгалзуулна уу?

/6 оноо/

a	Соёл	1	Хэн нэгэнд өөр соёлын орчинд орсноос бий болсон сэтгэл зүйн цочрол
b	Соёлын нэгдэл	2	Тухайн улс үндэсний нийтийн хүртээл болсон итгэл үнэмшил зан байдлын хэв маяг үнэлэмж болон институтуудын цогц нэгдэл
c	Соёлын орон зай	3	Хүний үйл ажиллагааны үр дүн болж үеэс үед өвлөгддөг тэдгээрийг хүн олж эзэмшдэг мэдлэг, итгэл үнэмшил, ёс суртахуун зан заншил болон бусад дадал чадварын нэгдэл
d	Соёлын цочирдол	4	Нийгэм-соёлын үнэлэмжүүдийн харилцан нөлөөллөөр бий болж байдаг оюун санааны орчин
e	Улс үндэстний соёл	5	Хүний бүтээл болохынхоо хувьд дэлхийн бүх улс ард түмний соёлд байдаг адил талууд
f	Соёлын нийтлэг шинж	6	Соёлд зүйл бүрийн хэм хэмжээ, үнэлэмж, ёс заншлууд нь бие биеэ дэмжиж өөр хоорондоо сайн зохицож нягтралтай байх шинж

2.2 Дараах өгөгдлийг зөв харгалзуулна уу?

/6 оноо/

a	Хүн капиталын хөрөнгө оруулалт	1	Төсвийн зарлагаас орлого давах үе
b	Эдийн засгийн интенсив өсөлт	2	Төсвийн орлогоос зардал давах тохиолдол
c	Эдийн засгийн өсөлт	3	Ажилчдын мэргэжил дээшлүүлэх болон түүнийг хөгжүүлэхэд чиглэгдсэн хөрөнгө оруулалт
d	Эдийн засгийн экстенсив өсөлт	4	ДНБ эсвэл нэг хүнд ногдох ДНБ-ний бодит хэмжээний өсөлт
e	Улсын төсвийн хомсдол	5	Нөөцийн тоо хэмжээг нэмэгдүүлэх замаар бий болсон эдийн засгийн өсөлт
f	Улсын төсвийн илүүдэл	6	Нөөцийн бүтээмжийн өсөлтийг хангах замаар бий болсон эдийн засгийн өсөлт

2.3 Дараах өгөгдлийг зөв харгалзуулна уу?

/6 оноо/

a	Хууль	1	Гэм буруутай, төлбөр төлөгч тал
b	Хариуцагч	2	Хуулиар тогтоосон ял шийтгэл хүлээх гэм буруугийн төрөл
c	Хариуцлага	3	Өмчлөх буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрх, үүрэг бүхий байгууллага
d	Хохирол	4	Гэм буруутай этгээд буруутай үйлдлийнхээ төлөө бусдын өмнө хүлээх үүрэг
e	Хуулийн этгээд	5	Гэмт үйлдлийн үр дүнд бий болсон алдагдал, гэмтэл, төлбөр
f	Эрүүгийн хариуцлага	6	Төрөөс тогтоосон заавал биелүүлэх хэм хэмжээний цогц

2.4 Дараах өгөгдлийг зөв харгалзуулна уу?

/6 оноо/

a	Улс төр /өргөн утгаар/	1	Ноёрхлыг иргэд эерэгээр үнэлж хүлээн авах, удирдуулах, захирагдахыг хүлээн зөвшөөрөх явдал
b	Улс төр /явцуу утгаар/	2	Төрийн баримт бичигт хуульчлагдан тусгагдаж эрх зүйн хэм хэмжээ болж баталгаажих
c	Улс төрийн засаглалын нөөц	3	Нийгэм дэх захирах, захирагдах ёсны харилцааг тодорхой бүтцэд оруулах, өөрөөр хэлбэл нэг талаас нийгмийн давуу байдалтай холбоо бүхий удирдлагын хөдөлмөр, нөгөө талаас гүйцэтгэх үйл ажиллагааны хоорондын хуваарийг зохион байгуулалтын хувьд тогтоон бэхжүүлэх явдал
d	Легитим шинж	4	Төр ба орон нутгийн байгууллагууд тэдний бодлого, зорилго, үйл ажиллагааны хэрэгжих талаар, тэдгээрийн талаарх хүмүүс бүлгүүдийн маргаан мэтгэлцээн зөрчил, тэмцэл зөвшилцөл, эвлэрэл зэргийг багтаадаг ойлголт
e	Легаль шинж	5	Төр засгийн үйл хэрэгт төдийгүй төрийн бус байгууллагууд сүм хийд, гэр бүл зэрэгт хамааралтай бөгөөд тэдгээр институтын хүрээнд нөөцийг хэрхэн ашиглах хуваарилах тухай зөрчилдөөн, яриа хэлэлцээр, хамтын ажиллагай зэрэг бүхий л үйл ажиллагаа
f	Улс төрийн ноёрхол	6	Улс төрийн засгийг гартаа авч тогтоон барих хэрэгжүүлэх бололцоог олгож байдаг эдийн засаг, нийгэм, оюун санааны хүчин зүйлс, арга хэрэгсэлүүд

